



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 06 сарын 23 өдөр

Дугаар А/56

Мандалговь

Нөхцөл байдлын үнэлгээ хийх тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 19 дүгээр зүйлийн 19.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сайнцагаан сумын Айраг багийн иргэн А.Батхүүгийн гэр бүлд нөхцөл байдлын үнэлгээ хийж, хамгааллын хариу үйлчилгээг 2021 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрүүдэд Төв аймгийн Мөнгөнморьт суманд очиж зохион байгуулсугай.

2. Нөхцөл байдлын үнэлгээ хийхэд шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Нөхцөл байдлын үнэлгээ хийхэд шаардагдах 215896 (Хоёр зуун арван таван мянга найман зуун ерин зургаа) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бүжинлхам)-д үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2021 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Бүжинлхам)-д даалгасугай.

ДАРГА



Ц.ГАНЗОРИГ

481190111

Дундговь аймгийн Гэр бүл, хүүхэд,
залуучуудын хөгжлийн газрын даргын
2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн
1156 тоот тушаалын 01 дүгээр хавсралт



НӨХЦӨЛ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХЭД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Хэрэглэгдэхүүн	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Шатахуун	138,3	1560	215896
Нийт				215896

-----oOo-----